



АРХАНГАЙ АЙМГИЙН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2020 оны 05 сарын 25 өдөр

Дугаар А/87

Эрдэнэбулган сум

Хүүхэд, нярайн эндэгдлийг бууруулах
ажлыг эрчимжүүлэх тухай

Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн 2020 оны 05 дугаар сарын 21-ний өдрийн 335 тоот зөвлөмж, ЭМГазрын хүүхэд нярайн эндэгдлийн шалтгааныг магадлан хэлэлцэх багийн 2020 оны нэгдүгээр улирлын хурлын шийдвэрийг хэрэгжүүлэх зорилгоор ТУШААХ НЬ:

1. Сумын Эрүүл мэндийн төвүүдийн хүүхдийн тусламж хариуцсан эмч нарыг Нэгдсэн эмнэлгийн хүүхдийн тасагт дадлагажуулах сургалтад хамруулах хуваарь, нэрсийг нэгдүгээр, Нэгдсэн эмнэлгийн хүүхдийн тасгийн эмч нарын, сумдын эмч нарт хийх цахим сургалтын удирдамжийг хоёрдугаар, Нярайн эрт үеийн нэн шаардлагатай тусламжийн чиглэлээр сумын Эрүүл мэндийн төвүүд дотооддоо сургалт зохион байгуулж, өөрийн үнэлгээ хийж, мэдээ ирүүлэх удирдамжийг гуравдугаар, хүүхдийн осол гэмтлээс сэргийлэх 6 сарын аян зохион байгуулах удирдамжийг дөрөвдүгээр хавсралтаар тус тус баталсугай.
2. Тушаалын хэрэгжилтийг ханган ажиллахыг Нэгдсэн эмнэлэг, Сум дундын эмнэлэг, сум, өрхийн Эрүүл мэндийн төвүүдийн дарга нарт үүрэг болгосугай.
3. Тушаалыг хэрэгжүүлэхэд мэргэжил арга зүйгээр ханган ажиллахыг Эмнэлгийн тусламж үйлчилгээний хэлтсийн дарга /Н.Пүрэвдулам/, Нийгмийн эрүүл мэндийн хэлтсийн дарга /Д. Алтантуяа/ нарт тус тус үүрэг болгосугай.
4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эмнэлгийн тусламж үйлчилгээний хэлтсийн дарга /Н.Пүрэвдулам/-д даалгасугай.

ДАРГА  Р. ГАНДИЙМАА



65100001.1

Эрүүл мэндийн газрын даргын
2018 оны 05 дугаар сарын 29 ний
өдрийн 118 тоот тушаалын 1 дүгээр хавсралт



СУМДЫН ХҮҮХДИЙН ТУСЛАМЖ ХАРИУЦСАН ЭМЧ НАРЫГ
НЭГДСЭН ЭМНЭЛГИЙН ХҮҮХДИЙН ТАСАГТ ДАДЛАГАЖУУЛАХ
СУРГАЛТАД ХАМРУУЛАХ УДИРДАМЖ

Нэг. Зорилго: Сумдын хүүхдийн тусламж хариуцсан эмч нарын хүүхдэд үзлэг хийх арга барил, оношилгоо, эмчилгээний талаарх мэдлэгийг дээшлүүлэх, өвчний түүхийг стандартын дагуу бичиж хэвших, аппарат тоног төхөөрөмжтэй ажиллах дадал эзэмшүүлэхэд оршино.

Хоёр. Хугацаа: Батлагдсан хуваарийн дагуу ирж ажиллана.

Гурав. Сумдын эмч нарын хүлээх үүрэг:

- 3.1. Дадлагажих сургалтад хамрагдах эмч нар урьдчилан хамар, хөөмийн шинжилгээ өгч, өөрчлөлт илэрсэн тохиолдолд эмчилгээ хийлгэсэн байна.
- 3.2. Дадлагажих сургалтад хамрагдах эмч нар батлагдсан хуваарийн дагуу Нэгдсэн эмнэлгийн хүүхдийн тасагт ирж ажиллана.
- 3.3. Ажиллахаар ирэхдээ сургалтын хугацаанд юу сурч мэдэхийг хүсч байгааг тусгасан хөтөлбөр боловсруулж, Нэгдсэн эмнэлгийн эмчилгээ эрхэлсэн орлогч даргаар батлуулна.
- 3.4. Сургалтад хамрагдаж байгаа эмч нар нь ажлын цагийг нарийн баримтлан ажиллах ба өглөө, орой тасгийн эрхлэгчид цагаа бүртгүүлнэ.
- 3.5. Холбогдох анхан шатны бичиг баримт, хүүхдийн өвчний түүх, картыг батлагдсан өнгийн бэхээр, стандарт удирдамжийн дагуу бичнэ.
- 3.6. Тасагт 1 удаа жижүүр эмчийн хамт жижүүр хийнэ.
- 3.7. Тасагт ажиллахдаа халдвар хамгааллын дэглэмийг чанд баримтлана.
- 3.8. Өвчтөн, сахиур, эмнэлгийн ажилчидтай эелдэг харьцаж ёс зүйн зөрчил гаргалгүй ажиллана.
- 3.9. Тасагт өвчтөн багатай үед амбулаторийн эмчтэй хамт хүүхэд үзэж, эцэг эхэд зөвлөгөө өгнө.
- 3.10. Тасгийн яаралтай тусламжийн өрөөний зохион байгуулалт, сэхээн амьдруулах, эрчимт эмчилгээнд хэрэглэх багаж тоног төхөөрөмжийн ажиллах горим, бэлэн байдалтай танилцаж, аль болох ихийг сурч мэдэх эрмэлзэлтэй, санаачлагатай ажиллана.
- 3.11. Эрчимт эмчилгээний хуудас хөтлөлтийг сурч эзэмшинэ.
- 3.12. Сургалтын төгсгөлд сурч мэдсэн зүйл, хийсэн ажлын талаар тайлан бичиж, тасгийн эрхлэгчээр үнэлгээ хийлгэж, сургалтын ирцийг баталгаажуулсан байна.

3.13. Сургалтын сүүлийн өдрийн 17 цагт дадлагажих сургалтаар олж авсан мэдлэг, сургалтын үр дүн, санал, цаашид сумын Эрүүл мэндийн төвд очоод хэрэгжүүлэх үйл ажиллагааг тусгасан тайлангаа Эрүүл мэндийн газрын Эмнэлгийн тусламжийн хэлтэст бичгээр өгнө.

Дөрөв. Хүүхдийн тасгийн эрхлэгч болон эмч нарын үүрэг:

- 4.1. Эрхлэгч эмч нь сумдаас ирсэн эмч нарыг хүлээн авч, дагалдуулан ажиллах эмч нарыг хуваарилана.
- 4.2. Эрхлэгч эмч нь сумын эмч нарын цагийг бүртгэж ажлын цаг ашиглалтад хяналт тавина.
- 4.3. Өвчний түүх бичих, бусад анхан шатны маягт хөтлөх талаар заавар зөвлөгөө өгнө.
- 4.4. Хүүхдийн тасгийн эмч нар нь, сумын эмч нарт хэвтэн эмчлүүлж байгаа хүүхдүүдээс хуваарилан, үзлэг хийлгэж, эмчилгээ, өвчний түүх бичилтэд байнга хяналт тавьж, заавар зөвлөгөө өгч хамтран ажиллана.
- 4.5. Хүүхдийн эмч нар, сумын эмчийг чадавхижуулах талаар санаачлагатай ажиллаж, тодорхой сэдвээр үүрэг өгөн уншуулж, онолын мэдлэгийг шалгах, лекц унших, гардан үйлдлийн дадлага хийлгэх зэргээр үр дүнтэй сургалт зохион байгуулна.
- 4.6. Сургалтын төгсгөлд хүүхдийн тасгийн эрхлэгч нь сумын эмч нарын хийсэн ажлын тайлантай танилцаж, сурч мэдэх зүйлийн талаар гаргасан хөтөлбөртэй тулган, үнэлгээ өгнө.

Тав. Сумдын хүүхдийн тусламж хариуцсан эмч нарын, Нэгдсэн эмнэлгийн хүүхдийн тасагт ажиллах хуваарь

д/д	Сумын нэр	Эмчийн нэр	Мэргэжил	Хүүхдийн тасагт ажиллах хугацаа
1	Чулуут	Лхагвасүрэн	Ерөнхий мэргэжлийн эмч	2020.06.08- 2020.06.13
2	Ихтамир	О. Заяабат	Ерөнхий мэргэжлийн эмч	2020.06.08- 2020.06.13
3	Жаргалант	Раднаасэд	Уламжлалтын эмч	2020.06.15- 2020.06.19
4	Цахир	Б. Хүчнэмэх	Ерөнхий мэргэжлийн эмч	2020.06.15- 2020.06.19
5	Эрдэнэмандал	З. Мөнхзул	Хүүхдийн эмч	2020.06.22- 2020.06.26
6	Батцэнгэл	Гүрбазар	Ерөнхий мэргэжлийн эмч	2020.06.22- 2020.06.26
7	Булган	А. Сурмаажав	Дотрын эмч	2020.06.29- 2020.07.03
8	Өлзийт	Хандсүрэн	Уламжлалтын эмч	2020.06.29- 2020.06.03
9	Хангай	Мөнхзул	Уламжлалтын эмч	2020.07.06- 2020.07.10
10	Өгийнуур	Х. Нэргүй	Хүүхдийн эмч	2020.07.06- 2020.07.10

11	Өндөр –Улаан	Долгорсүрэн	Хүүхдийн эмч	2020.07.13- 2020.07.17
12	Хайрхан	Дэлгэржаргал	Хүүхдийн эмч	2020.07.13- 2020.07.17
13	Цэцэрлэг	Мөнхзул	Ерөнхий мэргэжлийн эмч	2020.07.20- 2020.07.24
14	Тариат	Ж. Батжаргал	Мэдээгүйжүүлгийн эмч	2020.07.20- 2020.07.24
15	Хоршоолол	Анхпүрэв	Уламжлалтын эмч	2020.07.20- 2020.07.24
16	Цэнхэр	Ө. Мөнхшүр	Хүүхдийн эмч	2020.07.27- 2020.07.31
17	Хотонт	Энхзаяа	Хүүхдийн эмч	2020.07.27- 2020.07.31
18	Хашаат	Б. Батцэцэг	Ерөнхий мэргэжлийн эмч	2020.08.03- 2020.08.07
19	Төвшрүүлэх	Өлзий-Утас	Ерөнхий мэргэжлийн эмч	2020.08.03- 2020.08.07

Эрүүл мэндийн газрын даргын
2020 оны 05 дугаар сарын 29-ний
өдрийн 11/87 тоот тушаалын 2 дугаар хавсралт

НЭГДСЭН ЭМНЭЛГИЙН ХҮҮХДИЙН ТАСГИЙН ЭМЧ НАРЫН,
СУМ ӨРХИЙН ЭМЧ НАРТ ХИЙХ ЦАХИМ СУРГАЛТЫН УДИРДАМЖ

Нэг. Удиртгал:

Архангай аймгийн хэмжээнд 2020 оны 1-р улиралд 0-5 насны 11 хүүхэд эндсэн нь улс, аймгийн дундажтай харьцуулахад өндөр үзүүлэлттэй байна. Мөн нийт эндэгдлийн 7 тохиолдол буюу 63.6 хувь нь суманд эндсэн тул, сумдын Эрүүл мэндийн төвүүдийн хүүхдийн тусламж үзүүлдэг эмч, мэргэжилтнүүдийн мэдлэг, ур чадварыг нэмэгдүүлж, тусламжийн чанарыг сайжруулах зайлшгүй шаардлагатай байна.

Хоёр. Зорилго: Сумдын хүүхдийн тусламж хариуцсан эмч нарын мэдлэгийг нэмэгдүүлж, нярайн эрт үеийн нэн шаардлагатай тусламжийн болон хүүхдийн өвчний цогц менежментийн хэрэгжилтийг хангаж, хүүхдэд үзүүлэх тусламжийн чанарыг сайжруулах, эндэгдлийг бууруулахад оршино.


Гурав. Хугацаа: 2020.06.09-ний 14:30 цагт

Дөрөв. Хаана: Эрүүл мэндийн газрын сургалтын А танхимд

Тав. Хариуцах эзэн: Нэгдсэн эмнэлгийн эмчилгээ эрхэлсэн орлогч дарга, хүүхдийн тасгийн эмч нар

Зургаа. Хамрах хүрээ: Сум дундын эмнэлэг, сум, өрхийн Эрүүл мэндийн төвүүдийн эмч, мэргэжилтнүүд

Эрүүл мэндийн газрын даргын
2020 оны 08 дугаар сарын 24 ний
өдрийн 11/8 тоот тушаалын 3 дугаар хавсралт



НЯРАЙН ЭРТ ҮЕИЙН НЭН ШААРДЛАГАТАЙ ТУСЛАМЖИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР ДОТООД СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАХ УДИРДАМЖ

Нэг. Удиртгал: Архангай аймгийн хэмжээнд 2020 оны 1-р улиралд 0-5 насны хүүхдийн эндэгдэл 11 тохиолдол, үүнээс 8 нь нялхасын эндэгдэл байна. Нялхасын эндэгдэл 1000 амьд төрөлтөд 19.7 нэгж байгаа нь өмнөх оны мөн үеэс 4.5 нэгжээр өссөн байна. Нийт нялхасын эндэгдлийн 3 тохиолдол буюу 37.5 хувь нь нярайн эндэгдэл эзэлж байгаа бөгөөд бүгд эрт нярайн эндэгдэл бүртгэгдсэн нь нярайн эрт үеийн нэн шаардлагатай тусламжийн хэрэгжилтийг сайжруулах зайлшгүй шаардлагатай байгааг илтгэж байна. Иймээс сумын эрүүл мэндийн төвүүдийн Удирдлагын баг, Эмнэлгийн тусламж үйлчилгээ, чанар аюулгүй байдлын баг, Сувилахуйн багууд хамтран "Нярайн эрт үеийн нэн шаардлагатай тусламж"-ийг хэрэгжүүлэх дотоод сургалтын хөтөлбөр боловсруулан, сургалтыг үечилсэн байдлаар, тогтмол зохион байгуулж, үнэлгээ хийнэ.

Хоёр. Зорилго: Шинээр төрсөн нярайд үзүүлэх тусламжийн бэлэн байдлыг хангах, нярайн эрт үеийн нэн шаардлагатай тусламжийн хэрэгжилтийг сайжруулах, эмч мэргэжилтнүүдийн мэдлэг, ур чадварыг байнга сэргээж, хожимдол гаргалгүй чанартай, зөв тусламж үзүүлэх нөхцлийг бүрдүүлэхэд оршино.

Гурав. Хамрах хүрээ: Сум дундын эмнэлэг, сумын эрүүл мэндийн төвүүдийн эмч мэргэжилтнүүд

Дөрөв. Хугацаа: 2020 оны 06 дугаар сарын 01-нээс эхлэн жилийн турш хэрэгжүүлнэ.

Тав. Тайлан ирүүлэх: Дотоод сургалтын тайланг 2020 оны 12 дугаар сарын 10-нд Эмнэлгийн тусламжийн хэлтэс /Н.Пүрэвдулам/-т цаасан болон цахимаар ирүүлнэ.

Эрүүл мэндийн газрын даргын
2020 оны 08 дугаар сарын 09-ний
өдрийн 185 тоот тушаалын 4 дүгээр хавсралт

ХҮҮХДИЙН ОСОЛ ГЭМТЛЭЭС СЭРГИЙЛЭХ 6 САРЫН АЯН ЗОХИОН БАЙГУУЛАХ УДИРДАМЖ

Нэг. Удиртгал:

Улсын хэмжээнд 2020 оны нэгдүгээр улиралд 0-5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн шалтгаанд осол гэмтэл өмнөх оны мөн үеэс 3.5 пунктээр өссөн байна. Архангай аймагт 2020 оны нэгдүгээр улирлын 0-5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн тэргүүлэх шалтгаан нь осол гэмтэл болж байгаа бөгөөд, 4 тохиолдол буюу 36.4 хувийг эзэлж байна. Иймээс хүүхдийн осол гэмтлээс сэргийлэх аяныг зохион байгуулж, хүүхдийн эндэгдлийг бууруулах олон талт ажлуудыг зохион байгуулах шаардлагатай байна.

Хоёр. Зорилго: Хүүхдийн эндэгдлийн тэргүүлэх шалтгаан болж байгаа осол гэмтэл, золгүй тохиолдлыг бууруулан ажиллаж, хүүхдийн эрүүл мэндийг хамгаалахад оршино.

Гурав. Хамрах хүрээ: Сум дундын эмнэлэг, сум, өрхийн эрүүл мэндийн төвүүдийн эмч мэргэжилтнүүд

Дөрөв. Хугацаа: 2020 оны 06 дугаар сарын 01-нээс 2020 оны 11-р сарын 30-ныг дуустал 6 сарын турш хэрэгжүүлнэ.

Тав. Аяны хүрээнд хийх ажлын чиглэл:

- Эрүүл мэндийн төвүүд аяны хүрээнд хийх ажлын төлөвлөгөө боловсруулан гаргах
- Аяны үйл ажиллагаанд эрүүл мэндийн төвийн нийт ажилчдыг хамруулж, гүйцэтгэх үүрэг, хариуцах ажлын чиглэлийг тодорхой болгох
- Гаргасан төлөвлөгөөний дагуу, хуваарьт ажлуудыг цаг хугацаанд нь үр өгөөжтэй хийж хэрэгжүүлэх
- Тайланг 2020 оны 12 дугаар сарын 10-нд Эмнэлгийн тусламжийн хэлтэс /Н.Пүрэвдулам/-т цаасан болон цахимаар ирүүлэх

Зургаа. Үр дүн:

1. Эрүүл мэндийн төвийн эмч, мэргэжилтнүүд “Хүүхдийн осол гэмтлээс сэргийлэх” сэдвээр өөр хоорондоо болон эцэг эхчүүдэд сургалт зохион байгуулсан байна.
2. Иргэд, эцэг эхчүүд болзошгүй осол гэмтэл, золгүй тохиолдлоос хүүхдээ сэргийлэх эрүүл мэндийн боловсрол дээшилсэн, тусламж хайх мэдлэг сайжирсан байна.
3. Осол гэмтэл, золгүй тохиолдлын шалтгаант хүүхдийн нас баралт буурсан байна.